



СЭЛЭНГЭ АЙМАГ
АЛТАНБУЛАГ СҮМҮН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 2 өдөр

Дугаар A/114

Алтанбулаг

Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн
бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг
цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Улсын Онцгой комиссын даргын 2021 оны "Түр журам батлах тухай" 46 дугаар тушаал, Сэлэнгэ аймгийн Онцгой комиссын 2021 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 17 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын хэмжээнд коронавируст халдварт /Ковид-19/-ын цар тахалтай тэмцэх, хариу арга хэмжээг эрчимжүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн хуулийн этгээдийг 2021 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 06:00 цаг хүртэл хугацаанд Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын "Улбар шар" тувшинд шилжүүлсэн хугацааг 2021 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 06:00 цагаас эхлэн цуцалсугай.

2. Улсын Онцгой комиссын даргын 2021 оны "Түр журам батлах тухай" 46 дугаар тушаалын хэрэгжилтийг ханган, зохион байгуулалтын арга хэмжээ авч удирдлагаар ханган ажиллах, хяналтын цэгүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлж алба хаагчдын бэлэн байдал, халдварт хамгааллын дэглэмийг чангатгаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн (Д.Амартувшин)-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Шуурхай штабын дарга (Ү.Янжиндулам), Цагдаагийн хэсгийн дарга, цагдаагийн дэд хурандаа (Д.Наан), сумын Эрүүл мэндийн төвийн дарга (Ү.Энхбямба) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ОТГОНЦОГТ

